



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/05

Хөхбүрд

**Ц.Нямсүрэнд тамхины зөвшөөрөл
олгох тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Мандалхайрхан 1 дүгээр багийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг Наранмандал энтерпрайзес ХХК-ний талбайд хүнсний худалдаа эрхэлдэг Ц.Нямсүрэнд тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

2.Тамхи худалдаалах түүгээр үйлчлэхэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Л.Гүндцамба)-д хариуцуулсугай.

3.Зөвшөөрөл олгох Улсын тэмдэгтийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж ажиллахыг Татварын хураагч (Г.Ууганжаргал)-д даалгасугай.

4.Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг иргэн (Ц.Нямсүрэн)-д анхааруулсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

• 642201157